


Яаралтай тусламжийн тасагт хандах өвчтөнийг урьдчилан ангилах

Цар тахал хэмээн зарлагдсан COVID-19 нь маш олон сөрөг үр дагаварыг авчирч байгаа бөгөөд АНУ-ын эрүүл мэндийн дэд бүтэцийн ялгаатай байдлыг тодорхой харуулж байна. Эмчилгээний арга нь тогтоогдоогүйгээс, халдвар авсан хүнийг хянах, хязгаарлах нь одоогоор хамгийн үр дүнтэй арга хэмээгдэж байна.

EagleForce Health (EFH) нь Эрүүл Мэндийн Үндэсний хүрээлэнгээс санхүүжүүлсэн програмын давуу талыг хэрэглэн, өвчний явцыг загварчилан, тандалт болон хязгаарлалтын үйл явцыг шаталлаа. Хяналтын аргазүйн үндэслэл ба эм, дархлаажуулалтыг хянах системийн (MIMI-Rx) тайлбарыг доор үзүүлэв.

БНХАУ-ын Ухань хотын COVID-19-ийн халдвар авсан өвчтөний талаархи судалгааны үр дүнгээс харахад, халдварын анхны шинж тэмдэгт халуурах, зүрхний цохилт болон амьсгал олшрох, түүнчлэн хүчилтөрөгчийн ханалт буурах зэрэг орж байна. Эдгээр шинж тэмдэгийг эрт тодорхойлсоноор халдварын тохиолдлыг эрт илрүүлэх болон зохих арга хэмжээ авах боломжтой болно. Хэвтэн эмчлүүлэгсэдийн цусны шинжилгээнд цусны цагаан эс, Д-даймар, С-реактив уураг, креатинин киназ, прокалцитонин, креатининий хэмжээ нэмэгдэх зэрэг олон өөрчлөлтүүд ажиглагдсан байна.

Эдгээр шинжилгээ нь өргөн хэрэглэгддэг сорилууд бөгөөд COVID-19-ийн тест байхгүй тохиолдолд хоёрдогч сорил болгон ашиглах боломжтой. Судалгаанд хамрагдсан бүх өвчтөнүүдийн цээжний СТ шинжилгээгээр хоёр уушгинд үрэвсэлт өөрчлөлт байгааг илрүүлсэн байна. Бүх эрүүл мэндийн тогтолцоо нь СТ шинжилгээ хийх боломжгүй бөгөөд биеийн дулааны болон хүчилтөрөгчийн өөрчлөлт нь COVID-19 халдварыг эрт илрүүлэх үзүүлэлт болох боломжтой. Эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэнээс эрчимт эмчилгээний тасагт хэвтэх хүртэлх хугацаа, ойролцоогоор 10 хоног байсан гэж Ухань хотын COVID-19 судалгаанд тэмдэглэжээ. Энэ хугацаа нь COVID-19-ийн эрт илрүүлэлт болон бусад өвчнийг оношлох, эмчлэх боломжийг олгож байна. Түүнчлэн, томуугийн үед хэрэглэгддэг “нэг тун, нэг өдөр” эмчилгээг өдөөх боломжтой. “Нэг тун, нэг өдөр” эмчилгээний арга нь COVID-19-ийн оношлогоо эмчилгээнээс үүдэх боломжтой хэт их ачааллыг бууруулахад нэн хэрэгтэй.



Ухаалаг гэрлэлтийн ангилал. EagleForce Health, 2020.

Яаралтай тусламжийн тасагт хандах өвчтөнийг урьдчилан ангилах

MIMI-Rx нь эмнэлзүйн орчинд хэрэглэгдэхээр тохируулан хийгдсэн бөгөөд эмнэлзүйн шинж тэмдгийг эрт сэрэмжлүүлэх зорилготой болно. Халууралт, түүнтэй холбоотой хүчилтөрөгчийн ханалт (O₂) зэрэг өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх замаар өндөр настан, суурь өвчлөлтэй хүмүүс, нэг дүгээр зэргийн хандалттай хүмүүсийн (сургуулийн хүүхдүүд) эмнэл зүйн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг хянах боломжтой юм. Энэхүү арга нь энгийн бөгөөд үр дүнтэй ба COVID-19 болон бусад томуу, томуу төст өвчнийг эрт илрүүлэн, сэрэмжлүүлэхэд ашиглаж болно. Ухаалаг гурвалсан ангилал нь MIMI-Rx-д бүртгэгдсэн баримттай мэдээлэл дээр үндэслэгдэх ба CDC-ийн өвчтөн өөрийгөө хянах, өвчтөнг ангилах бодлоготой тохирч байгаа юм. Халдвар авсан өвчтөн уг платформыг хэрхэн хэрэглэх нь улс даяар тархсан цар тахалд хэрэглэсэн хэрэглээг харуулах жишээ платформ болох болно.

EFH шийдэл нь патентлагдсан бөгөөд, тухайн хүний онцлогт тохируулан эмнэл зүйн шинжилгээ, үзлэгт үндэслэн харилцан уялдаатай, бодит цагийн дүн шинжилгээ хийн, ангилал болон үнэлгээ өгөх аюулгүй платформыг бий болгох зорилготой. Тэрчлэн төвлөрсөн үүлэн платформуор дамжуулж муж хоорондын болон муж дотор мэдээллийг хялбархан дамжуулах ба бүрэн бус мэдээллээс зайлсхийх боломжийг олгоно. Өвчтөн MIMI-Rx програмыг Google болон Apple програмын дэлгүүрүүдээс үнэгүй татаж авах боломжтой.

Улс даяар хийгдэж буй халдварын дэгдэлтийг бууруулах хүчин чармайлт нь одоо ашиглагдаж байгаа мэдээлэл цуглуулах үйл явц болон хялбар бус оношлогооны арга зэргийн улмаас дугагдаж буй тусламж үйлчилгээг харилцаа холбоо болон технологээр тусламжтай шийдвэрлэгдэнэ. Халварыг эрт илрүүлэх, өвчтөн өөрийгөө хянах болон өвчтөнг ангилах нь энэхүү цар тахалын улмаас үүсэх эмнэлгийн хэт их ачаалалаас сэргийлэх боломжыг өгөх бөгөөд өргөн хүрээнд хэрэглэх боломжтой, харилцан уялдаатай өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нотлох баримтад суурилсан сэрэмжлүүлэг хийх шийдэл нь зайлшгүй хэрэгцээ болоод байна.